## НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 06 өдөр    Дугаар А/01    Улаанбаатар хот

2020 оны бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийн төлөвлөгөө, хөтөлбөр батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.2, 13.3.5 30 дугаар зүйлийн 30.3, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны "Сургалт бэлтгэлийг зохион байгуулах тухай" А/309, 2019 оны "2020 оны сургуулийн жилд сургалт бэлтгэлийг зохион байгуулах тухай" А/416 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2020 оны сургуулийн жилийн удирдамжийг нэгдүгээр, 2020 оны сургалт бэлтгэлийн төлөвлөгөөг хоёрдугаар, сургалтын хөтөлбөрийг гуравдугаар хавсралтаар тус тус батласугай.

2. Сургуулийн жилийн нээлтийг 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулж, дүнг 01 дүгээр сарын 16-ны өдрийн дотор цахимаар, бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийг 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс зохион байгуулж, сургуулийн эхний хагас жилийн дүнг 06 дугаар сарын 02, сургуулийн жилийн дүнг 12 дугаар сарын 02-ны өдрийн дотор Захиргааны удирдлагын хэлтэст ирүүлэхийг дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга, нийслэлийн Аврах анги-105-ын захирагч, Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Сургуулийн жилийн явц, үр дүнд хяналт тавьж удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Захиргааны удирдлагын хэлтэс (дэд хурандаа Б.Баттулга)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга (хурандаа Н.Нямхорлоо)-д тус тус даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА Ж.ЧҮЛТЭМСҮРЭН

D:/My documents-blank-2020-tushaal

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн
А/01 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

## 2020 ОНЫ СУРГУУЛИЙН ЖИЛИЙН УДИРДАМЖ

Сургуулийн жилийн зорилго:

Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг эзэмшсэн онолын мэдлэгт тулгуурлан дадлага олгох, сургалтын хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх замаар алба хаагчдын мэргэшсэн байдлыг хангаж, үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлнэ.

### Нэг. Сургуулийн жилийн зорилт

1.1. Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалтыг эрчимжүүлэх,

1.2. Сургалтыг онолын мэдлэгт тулгуурласан дадлага олгох, дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх,

1.3. Алба хаагчдад эх оронч үзэл, цэрэгжилт, жагсаалч байдлыг төлөвшүүлэх, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэл олгоход чиглүүлэх.

### Хоёр. Сургалт бэлтгэлд тавигдах шаардлага

2.1. Алба хаагчдын эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, тогтвортой ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлэх, сургалт бэлтгэлийн төлөвлөлт нь тооцоо судалгаанд үндэслэсэн сургуулийн жилийн зорилтууд, хөтөлбөрийг хангах боломжтой, суралцагчийн ээлт хэрэгцээнд нийцсэн байх;

2.2. Сургалтын үйл ажиллагаа, арга, хэлбэрт дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх, бие бүрэлдэхүүний бие даан сурч хөдөлмөрлөх, өөрийгөө хөгжүүлэх зарчимд тулгуурлан, дадлага зонхилсон хэлбэрээр явагдах, тэдний бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн байх;

2.3. Офицер бүрэлдэхүүн болон сургалт хариуцсан албан тушаалтан, сургагч багш нарын заах арга зүйн болон мэргэжлийн ур чадварыг тасралтгүй нэмэгдүүлэх;

2.4. Сургалт бэлтгэл тодорхой үр дүнд чиглэгдсэн, алба хаагч бүр үүргээ хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийн дагуу биелүүлэхэд сургагдсан байх;

2.5. Сургалт бэлтгэлд тавих хяналтыг сайжруулах, сургалтын зорилтыг хангуулах, сургалтын үед гаргасан зөрчил дутагдлыг илрүүлж, засахад чиглүүлэх;

2.6. Суралцагчдын үүрэг гүйцэтгэх үеийн сэтгэл зүйн бэлтгэлийг хангуулж, алба хаагчдад бие бялдар, сэтгэл зүйн өндөр чанарыг эзэмшүүлэх;

2.7. Сургалтын гарын авлага, ном товхимол, материаллаг баазыг бүрдүүлж, байнга сайжруулах.

### Гурав. Сургалт бэлтгэлийн зохион байгуулалт

3.1. 2020 оны Сургуулийн жилд "Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг зохион байгуулах ерөнхий журам" болон энэхүү удирдамжийн дагуу бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг зохион байгуулна.

3.2. 2020 оны сургуулийн жил 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 12 дугаар сарын 05-ны өдөр хүртэлх хугацаанд үргэлжилнэ. Сургуулийн жилийн эхний хагас-I үе нь 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэл, сүүлийн хагас-II үе нь 09 дүгээр сарын 05-ны өдрөөс 12 дугаар сарын 05-ны өдрийг хүртэлх хугацаанд тус тус хамарна.

3.3. "Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг зохион байгуулах ерөнхий журам"

болон энэхүү удирдамжийг бүтцийн нэгжийн дарга, захирагч нар бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг зохион байгуулах тухай тушаал гаргана.

Тушаалаар сургуулийн жилийн нээлтийн болон сургалт бэлтгэлийн хөтөлбөр, төлөвлөгөөг баталж, сургагч багш нарыг томилно.

Сургалт бэлтгэлийн хугацаанд дараах албан тушаалтан сургагч багшаар ажиллана. Үүнд:

- ➢ Захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн
- ➢ Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн
- ➢ Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн
- ➢ Гал түймэртэй тэмцэх хэлтсийн ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, гамшгаас хамгаалах болон Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч
- ➢ Санхүү, эдийн засгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, нягтлан бодогч, эдийн засагч, инженер,
- ➢ Дотоод хяналт шинжилгээ, үнэлгээ, эрсдэлийн удирдлагын тасгийн ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн,
- ➢ Нийслэлийн Аврах анги-105-ын захирагч, штабын дарга, мэргэжилтэн, бүлгийн дарга аврах ажиллагааны зааварлагч, эмч нар,
- ➢ Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвийн дарга, менежер, сургагч багш нар,
- ➢ Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга, орлогч, Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч, ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, автын инженер, механик, ахлах нягтлан бодогч Гал түймэр унтраах, аврах ангийн захирагч, Салааны захирагч нар.

3.4. Сургуулийн жилийн эхний хагаст танхимын сургалтыг түлхүү зохион байгуулж, алба хаагчдыг мэргэшлийн зэргийн шалгалтад бэлтгэж, тусгай хөтөлбөрөөр бэлтгэл хангуулахад чиглүүлнэ. Сургуулийн жилийн 2 үеийн хооронд дадлага, сургууль, хээрийн гаралтыг зохион явуулна.

3.5. Сургуулийн жилийн хүрээнд тухайн орон нутгийн газар зүйн байршил, цаг агаарын болон аюул, ослын нөхцөл байдалтай уялдуулан бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийн хөтөлбөр, төлөвлөгөө, дадлага сургуулийн хуваарийг уян хатан зохион байгуулна.

3.6. Сургагч багш нар сургалт бэлтгэлийн хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу заах хичээлийн конспектийг шинэчлэн боловсруулж орлогч, штабын дарга, менежерээр хянуулж дарга, захирагчаар батлуулна. Офицер бүрэлдэхүүн багшлах ур чадварыг эзэмшсэн, бие биеэ орлон ажиллах чадвартай байх шаардлага тавина.

3.7. Бүтцийн нэгжийн орлогч, штабын дарга, менежер нь сургагч багш нарыг чадавхжуулах, сургалтын арга зүй, технологийг боловсронгуй болгох, бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх ажлыг удирдан зохион байгуулна.

3.8. Штабын дадлага, хэсэгчилсэн болон хамтарсан дадлага сургууль, хээрийн гаралтыг зохион байгуулахдаа улирал, цаг агаарын нөхцөлийг тооцон, газар орон, байгууламжийг зөв сонгоно.

3.9. Дүүргийн Онцгой байдлын хэлтсүүд жилд 1 удаа тусгай төлөвлөгөө, удирдамжаар онолын мэдлэг, туршлага солилцох, харилцан ажиллагааны дадлага, сургуулийг зохион байгуулж, энэ тухай илтгэх хуудсыг ажлын 3 хоногт багтаан нийслэлийн Онцгой байдлын газарт ирүүлнэ.

3.10. Сургуулийн жилд офицер, ахлагчийн бүрэлдэхүүнд "Гамшгийн менежмент", "Эрүүл ахуй, Хөдөлмөрийн аюулгүй байдал", "Эрх зүйн үндэс", "Эрүүл мэнд-сэтгэл зүйн

бэлтгэл", "Биеийн тамирын бэлтгэл", "Ёс зүйн хүмүүжил", "Цэргийн хэрэг, жагсаалын бэлтгэл", "Гадаад хэлний бэлтгэл", "Мэргэжлийн бэлтгэл" хичээлүүдийг 7-14 хоногт тус бүр 1 удаа 1-2 цагийн багтаамжтайгаар төлөвлөнө.

Мөн алба хаагчдад монгол хэл найруулга, албан хэрэг хөтлөлтийн талаарх хичээлийг заавал орох, бусад сургалтын байгууллагатай хамтарч ажиллаж болно.

3.11. Сургалтын цагийн ачааллын 40 хүртэл хувийг онолоор, 60 хүртэл хувийг дадлагаар суралцуулна.

3.12. Зэвсэгт хүчний жанжин штабын даргын 2017 оны А/505 дугаар тушаалаар батлагдсан "Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт"-ын дагуу "Биеийн тамирын бэлтгэл" хичээлийг зохион байгуулна. Мөн стандартад заасан алба хаагчдын биеийн зохистой харьцааг сургуулийн жилийн үе бүрийн төгсгөлд буюу 5 болон 11 дүгээр сарын 05-ны өдрийн дотор тодорхойлж, дүн, мэдээг илтгэх хуудсаар нийслэлийн Онцгой байдлын газарт ирүүлнэ.

3.13. Гал түймэр унтраах, аврах ангиуд өдөр тутмын дадлага сургуулийг салаагаар, тархалтын сургуулийг салаа сард 1 удаа буюу анги 4 удаа, тактикийн сургуулийг улиралд 1 удаа зохион байгуулна. Тактикийн сургуулийг анги бие дааж болон хамтран зохион байгуулж болно.

3.14. Нийслэлийн Аврах анги-105 өдөр тутмын дадлага сургуулийг бүлгээр, эрэн хайх аврах ажиллагааны дадлага сургуулийг сард 1 удаа салбараар, улиралд 1 удаа хамтарсан дадлага сургуулийг явуулна.

3.15. Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэл, дадлага сургуулийн өмнө хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр зааварчилгаа өгч, явцад нь учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг дарга, захирагчаас авч хэрэгжүүлнэ.

3.16. Сургуулийн жилийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд бие бүрэлдэхүүний идэвх санаачилгыг өрнүүлэх зорилгоор ажил мэргэжлийн болон спортын тэмцээн, соёл хүмүүжлийн арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан сургалт бэлтгэл-соёл хүмүүжлийн ажлын нэгдлийг хангаж хэрэгжүүлнэ.

3.17. Алба хаагчдыг эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцох оролцоог нэмэгдүүлэх, анги, байгууллагын сургалт бэлтгэлийн төлөвлөгөөнд эрдэм шинжилгээний ажлыг тусгаж хэрэгжилтийг хангах, төрийн цэргийн байгууллагууд болон боловсролын байгууллага, бусад байгууллагаас зохион байгуулдаг эрдэм шинжилгээний хурлуудад алба хаагчдыг судалгааны ажил хийлгэж, илтгэл бэлтгүүлж хамруулах, үр дүнг тооцож ажиллана.

3.18. Албан томилолт, сургалтад хамрагдсан, өвчтэй, чөлөөтэй шалтгаанаар ажлын байранд нэг сараас дээш хугацаагаар ажиллаагүй алба хаагчидтай нэмэлт сургалтыг, сургуулийн жилийн төгсгөлийн болон мэргэшлийн түвшин тогтоох шалгалт, Онцгой байдлын ерөнхий газрын даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэг шалгалтаар "Дутагдалтай" болон "Хангалтгүй" үнэлгээтэй дүгнэгдсэн алба хаагчидтай давтан сургалтыг Нийслэлийн Онцгой байдлын газар болон бүтцийн нэгжийн удирдлагаас тусгайлан зохион байгуулна.

3.19. Сургуулийн жилийн эхэнд алба хаагчдын орос, англи хэлний мэдлэгийн түвшнийг тогтоож, суралцагчдын хэрэгцээ болон байгууллагын бодлогоор гадаад хэлний сургалтыг зохион байгуулна.

3.20. "Цэргийн хэрэг-жагсаалын бэлтгэл" хичээлийг 14 хоногт 1 удаа, алба хаагчдын цэргийн мэргэжил, боловсролын байдал, ажилласан жилийг харгалзан ялгавартайгаар зохион байгуулна.

3.21. Нийслэлийн Онцгой байдлын газрын бүтцийн нэгжийн дарга, захирагч нар алба хаагчдыг сургалтад бүрэн хамруулж, хяналт тавьж ажиллана.

Дөрөв. Сургалт бэлтгэлийн үнэлгээ болон сургуулийн жилийн дүн

4.1. Сургалт бэлтгэлийг шалгаж үнэлэх зааврын дагуу бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг шалгаж үнэлнэ. Сургалт бэлтгэлийн танхимын хичээл болон дадлагын явцыг гэрэл зургаар баталгаажуулсан байна.

4.2. Танхимын сургалтаар олгосон онолын мэдлэгийг судалсан сэдвийн дагуу тест, асуумж, билет боловсруулж, сэдвийн төгсгөл бүрд авч болно. Мөн алба хаагчдад хичээлийн агуулгын дагуу конспект боловсруулах, реферат бичих даалгавар өгөн гүйцэтгэлийг шалгаж үнэлэх, шилдэг конспект, реферат боловсруулсан алба хаагчийг шалгаруулан урамшуулж, туршлагыг түгээн дэлгэрүүлсэн байна.

4.3. Бүтцийн нэгжийн дарга, захирагч нар сард 1 удаа нийт бүрэлдэхүүнд хичээл заaж, улиралд 1 удаа удирдах бүрэлдэхүүний штабын дадлагыг удирдан явуулж, үнэлж дүгнэн, тайланг илтгэх хуудсаар Захиргааны удирдлагын хэлтэст ирүүлнэ.

4.4. Цэргийн хэрэг-жагсаалын бэлтгэлийг тестээр болон биеэр гүйцэтгүүлж, офицер бүрэлдэхүүнээс жагсаал командлах, удирдах байдлаар шалгаж, биеийн тамирын бэлтгэлийг бие бялдрын бэлтгэлжилтийн нормативын дагуу сар бүр авч түвшин ахисан байдалд дүн шинжилгээ хийнэ.

4.5. Аклагч бүрэлдэхүүний тусгай бэлтгэл хичээлийн ур чадварыг тактик, тархалтын сургууль дадлагын үед, офицер бүрэлдэхүүний байр зүйн зураг цагийн байдлыг оруулж шийдвэр гаргах байдлыг штабын дадлагын үеэр үнэлж дүгнэнэ.

4.6. Сургалт бэлтгэлийн үе бүрийн төгсгөлд буюу хагас жилийн шалгалтыг 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор авч, дүнг 06 дугаар сарын 02-ны өдөр, жилийн эцсийн төгсгөлийн шалгалтыг 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор авч үнэлж дүгнэнэ.

4.7. Бүтцийн нэгжийн дарга, захирагч нар сар бүр сургалт бэлтгэлийн явцтай танилцан гарын үсэг зурж баталгаажуулах, сургуулийн жилийн төгсгөлд сургалт бэлтгэлийн үр дүнгийн хурлыг удирдан зохион байгуулж, дүнг 12 дугаар сарын 02-ны өдрийн дотор Захиргааны удирдлагын хэлтэст ирүүлнэ.

4.8. Сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийн нэгдсэн дүнг Захиргааны удирдлагын хэлтэс 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор нийслэлийн Онцгой байдлын газрын Даргын зөвлөлийн хуралд танилцуулна.

---oOo---

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн
A/4 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

## НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙ 2020 ОНЫ СУРГАЛТ БЭЛТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилт: Сургалтыг онолын мэдлэгт тулгуурласан дадлага олгох, мөн дадлага ажил болон үүрэг гүйцэтгэх үед онолын мэдлэгийг эзэмшүүлэх хэлбэрээр тасралтгүй явуулж, алба хаагчдад эх оронч үзэл, эерэг хандлага төлөвшүүлэх, бие бялдар сэтгэл зүйн ев тэгш хүмүүжил олгоход чиглүүлнэ.

| № | Үе шат | Хичээлийн агуулга | Сэдэв | Зохион байгуулах хэлбэр, цаг: Лекц | Дадлага | Семинар | Бүгд |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ОФИЦЕР БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГАЛТ | | | | |
| 1 | Эхний хагас I үе | Гамшгийн менежмент | Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр, Гамшгаас хамгаалах тухай хууль | 1 | | | 1 |
| 2 | | | Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр | 1 | | | 1 |
| 3 | | | Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам, Гамшгийн эрсдэлийн үнэлгээний нийтлэг заавар | 1 | 1 | | 2 |
| 4 | | | Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар /Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаал/ | 1 | 1 | | 2 |
| 5 | | | Гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, дадлага зохион байгуулах заавар | 1 | | 1 | 2 |
| 6 | | | Төрөл бүрийн гамшгийн үед амьд гарах арга ухаан | | | 2 | 2 |
| 7 | | | Холбоо, зарлан мэдээллийг зохион байгуулах | 1 | 1 | | 2 |
| 8 | | | Гамшгийн нөхцөл байдлыг байр зүйн зурагт оруулах | 1 | 3 | | 4 |
| | | | БҮГД | 7 | 6 | 3 | 16 |
| | | | АХЛАГЧ БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГАЛТ | | | | |
| 1 | Эхний хагас I үе | Тусгай бэлтгэл | Гамшгаас хамгаалах менежментийн тухай ойлголт | 1 | | 1 | |
| 2 | | | Цэргийн байр зүйн зургийн тухай ойлголт | 1 | 1 | | |
| 3 | | | Газар зүйн координатын тухай | 1 | 1 | | |
| 4 | | | Сансарын иридиум утасны тухай ойлголт | 1 | 1 | | |
| 5 | | | Байршил тогтоох систем, GPS-ын ажиллах журам | 1 | 1 | | |
| 6 | | | Төрөл бүрийн нөхцөлд эрэн хайх, аврах ажиллагаа | 1 | | 1 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | | | Гамшгийн голомтод холбоо мэдээллийн зохион байгуулалт | 1 | | 1 | |
| 8 | | | Төөрсөн тохиолдолд зүг чигээ олох шинжлэх ухааны болон уламжлалт аргууд | 1 | | 1 | |
| | | | БҮГД | 8 | 4 | 4 | 16 |
| | | | ОФИЦЕР, АХЛАГЧ БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГАЛТ | | | | |
| 1 | Эхний хагас I үе | Эрх зүйн үндэс | Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого | 1 | | 1 | 2 |
| 2 | | | Батлан хамгаалах бодлогын үндэс, Монгол улсын Цэргийн номлол | 1 | | | 1 |
| 3 | | | Батлан хамгаалах салбарын Багц хуулиуд | 2 | | | 2 |
| 4 | | | Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль | 1 | | | 1 |
| 5 | | | Төрийн албаны тухай хууль | 1 | | 1 | 2 |
| 6 | | | Албан хаагчийн ёс зүйн дүрэм | 1 | | 1 | 2 |
| 7 | | | Гал түймэр унтраах дүрэм | 1 | 1 | | 2 |
| 8 | | | Галын хоолойн стандарт | 1 | | | 1 |
| 9 | | | Аврах олсны стандарт | 1 | | 1 | 2 |
| 10 | | | Тэсрэх бодис тэсэлгээний хэрэгсэлтэй харьцах,ослын үр дагаврыг арилгах үед баримтлах аюулгүй ажиллагааны заавар | 1 | | | 1 |
| | | | БҮГД | 11 | 1 | 4 | 16 |
| 1 | Эхний хагас I үе | Эрүүл мэнд-сэтгэл зүйн бэлтгэл | Эмийн зохистой хэрэглээ | 1 | | | 1 |
| 2 | | | Дасгал хийх /ажлын байрны дасгал/ | | 1 | | 1 |
| 3 | | | Архины хэрэглээ, хор хөнөөл | | | 1 | 1 |
| 4 | | | Тамхины хэрэглээ, хор хөнөөл | | | 1 | 1 |
| 5 | | | Мансууруулах бодисын хэрэглээ, хор хөнөөл | | | 1 | 1 |
| 6 | | | Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх арга, техник | | 1 | | 1 |
| 7 | | | Угаартсан хүнд үзүүлэх анхны тусламж | | 1 | | 1 |
| 8 | | | Тунэгдсэн хүнд үзүүлэх анхны тусламж | | 1 | | 1 |
| 9 | | | Гамшгийн голомтод ажиллаж буй бүрэлдэхүүний сэтгэл зүйн онцлог | 1 | | | 1 |
| 10 | | | Сэтгэл зүйн хэв шинжүүд | 1 | | | 1 |
| 11 | | | Стресс гэж юу вэ? | 1 | | | 1 |
| 12 | | | Стрессээс гарах арга замууд, стресст орохгүй байх аргууд | | | 1 | 1 |
| 13 | | | Депрессийн тухай ойлголт | 1 | | | 1 |
| 14 | | | Элэгний өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга | 1 | | | 1 |
| 15 | | | Хүнээс хүнд халдварладаг өвчний хүндрэл, сэргийлэх | 1 | | | 1 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | арга | | | | |
| 16 | | | Хүн, малын халдварт өвчний тухай ойлголт, сэргийлэх арга зам | 1 | | | 1 |
| | | | БҮГД | 8 | 4 | 4 | 16 |
| 1 | Эхний хагас I үе | Биеийн тамирын бэлтгэл | 32,64,128 тоот дасгал | | 2 | | 2 |
| 2 | | | Хүчний дасгал хөдөлгөөн | | 2 | | 2 |
| 3 | | | Цэргийн биеийн тамирын бэлтгэлжилтын норматив | | 6 | | 6 |
| 4 | | | Галын техникийн олон төрөлт спортын үүсэл хөгжил | | 2 | | 2 |
| 5 | | | Довтолгооны шатанд гүйх дадлага хийх | | 2 | | 2 |
| | | | БҮГД | | 14 | | 14 |
| 1 | Эхний хагас I үе | Цэргийн хэрэг жагсаалын бэлтгэл | Цэргийн жагсаалын дүрэм | 1 | | 1 | 2 |
| 2 | | | Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм | 1 | | | 1 |
| 3 | | | Зэвсэгт хүчний Дотоод албаны дүрэм | 1 | | | 1 |
| 4 | | | Цэргийн сахилгын дүрэм | 1 | | | 1 |
| 5 | | | Онцгой байдлын албанд алба хаах журам /2017-12-22/ | 1 | | | 1 |
| 6 | | | Жагсаалын бэлтгэл | | 10 | | 10 |
| | | | БҮГД | 5 | 10 | 1 | 16 |
| 1 | I үе | Гадаад хэлний бэлтгэл | Англи хэлний анхан шатны мэдлэг олгох | 4 | | 4 | 8 |
| 2 | | | Орос хэлний анхан шатны мэдлэг олгох | 4 | | 4 | 8 |
| | | | БҮГД | 8 | | 8 | 16 |
| 1 | Эхний хагас I үе | Ёс зүйн хүмүүжил | Төрийн алба хаагчийн ёс зүйн дүрэм | 1 | | 1 | 2 |
| 2 | | | Төрийн албаны ёс зүй | 4 | 1 | | 5 |
| 3 | | | Компьютерын ёс зүй | 1 | | 1 | 2 |
| 4 | | | Харилцааны ёс зүй | 4 | | 1 | 5 |
| 5 | | | Оюун ухаан сорьсон тэмцээн | 2 | | | 2 |
| | | | БҮГД | 12 | 1 | 3 | 16 |
| | | | ХАМТАРСАН БОЛОН НЭГДСЭН ДАДЛАГА СУРГУУЛЬ /2020 оны 05 сарын 18-аас 09 сарын 04-ний хооронд/ | | | | |
| 1 | Дунд үе | | Офицер бүрэлдэхүүний штабын дадлага | 1 өдөр | | | |
| 2 | | | Урсгал уснаас аврах ажиллагааны дадлага сургалт | 1 өдөр | | | |
| 3 | | | Усны гүнээс аврах ажиллагааны дадлага сургалт | 1 өдөр | | | |
| 4 | | | Өндөр уулнаас аврах ажиллагааны дадлага сургууль | 1 өдөр | | | |
| 5 | | | Агаарaас аврах ажиллагааны дадлага сургууль | 1өдө р | | | |
| 6 | | | Хөрш зэргэлдээ аймагтай хамтарсан дадлага сургууль | 1 өдөр | | | |
| | | | ОФИЦЕР, АХЛАГЧ БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГАЛТ | | | | |
| 1 | Сүүлийн хагас II үе | | Онцгой байдлын албаны товчилсон нэр, томъёолсон тэмдгийг байр зүйн зурагт оруулах | 1 | 1 | | 2 |
| 2 | | | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн заавар | 1 | 1 | | 2 |
| 3 | | Эрүүл ахуй, | ОББ-ын амьсгалын бие даасан | 1 | 1 | | 2 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хөдөлмөрийн аюулгүй байдал | төхөөрөмжтэй ажиллах үед дагаж мөрдөх дүрэм | | | | |
| 4 | | | Мал амьтныг зориуд устгах, булшлах үйл ажиллагааны заавар | 1 | 1 | | 2 |
| 5 | | | Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар | 1 | 1 | | 2 |
| 6 | | | Баримт бичгийг зохион бүрдүүлэх түүнд тавигдах шаардлага, стандарт | 1 | 1 | 1 | 3 |
| | | | БҮГД | 6 | 6 | 1 | 13 |
| 1 | Сүүлийн хагас II үе | Эрүүл мэнд-сэтгэл зүйн бэлтгэл | Хугарлын үед үзүүлэх анхны тусламж | | 1 | 1 | 2 |
| 2 | | | Халдалтын үед үзүүлэх анхны тусламж | | 1 | | 1 |
| 3 | | | Цус алдалтын үед үзүүлэх анхны тусламж | | 1 | | 1 |
| 4 | | | Усанд живсэн хүнийг аврах анхны тусламж үзүүлэх | 1 | 1 | | 2 |
| 5 | | | Амилуулах суурь тусламж | 1 | 1 | 1 | 3 |
| 6 | | | Сэтгэл зүйн сорил | | 1 | | 1 |
| 7 | | | Төрөл бүрийн анхны тусламжийг салаа бүлгээр гүйцэтгэх | | 1 | | 1 |
| 8 | | | Угаартсан иргэнд үзүүлэх анхны тусламж | | 1 | | 1 |
| 9 | | | Утаатай орчинд эрэн хайх ажиллагааг салаа,бүлгээр хийх | | 1 | | 1 |
| | | | БҮГД | 2 | 9 | 2 | 13 |
| 1 | Сүүлийн хагас II үе | Биеийн тамирын бэлтгэл | Биеийн тамирын бэлтгэлжилтийн нормативыг биелүүлэх | | 3 | | 3 |
| 2 | | | Ажил мэргэжлийн тэмцээн | | 3 | | 3 |
| 3 | | | Спортын уралдаан тэмцээн | | 3 | | 3 |
| 4 | | | 32,64,128 тоот дасгал | | 2 | | 2 |
| 5 | | | Хүчний дасгал хөдөлгөөн | | 2 | | 2 |
| | | | БҮГД | | 13 | | 13 |
| 1 | Сүүлийн хагас II үе | Цэргийн хэрэг жагсаалын бэлтгэл | Цэргийн дүрэм, жагсаалын дүрмийн дасгал, бэлтгэл /Газар, хэлтэс, Салаа, бүлгээр, нэгдсэн/ | | 13 | | 13 |
| | | | БҮГД | | 13 | | 13 |
| 1 | Сүүлийн хагас II үе | Гадаад хэлний бэлтгэл | Англи хэлний анхан шатны мэдлэг олгох | 4 | 2 | | 6 |
| 2 | | | Орос хэлний анхан шатны мэдлэг олгох | 4 | 3 | | 7 |
| | | | БҮГД | 8 | 5 | | 13 |
| 1 | Сүүлийн хагас II үе | Ёс зүйн хүмүүжил | Хувь хүний соёл | 1 | | 1 | 2 |
| 2 | | | Хөгжөөнт тэмцээн уралдаан зохион байгуулах | | 4 | | 4 |
| 3 | | | Төрөл бүрийн соён гэгээрүүлэх ажил | | 4 | | 4 |
| 4 | | | Гэр бүлийн уулзалт зохион байгуулах | | 3 | | 3 |
| | | | БҮГД | 1 | 11 | 1 | 13 |

--oOo--

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн
А/01 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

## БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГАЛТ БЭЛТГЭЛИЙН ЭХНИЙ ХАГАС I ҮЕ БОЛОН СҮҮЛИЙН ХАГАС II ҮЕД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

| д№ | Бүлэг сэдэв | Дэд сэдэв | Он, сар, өдөр | Цаг | Сургалтын хэлбэр | | | Хариуцах хэлтэс, Багш |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Лекц | Семинар | Дадлага | |
| ГАЗРЫН ОФИЦЕР, АХЛАГЧ БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГАЛТ<br>/Сард 2 удаа мэдээллийн цаг дээр баасан гаригт/<br>/7 хоног бүрийн лхагва гаригт 15:30-17:30 цагт "Аврагч" спорт хороонд биеийн ерөнхий хөгжлийн хичээлтэй/ | | | | | | | | |
| 1 | 2020 оны Сургуулийн жилийн нээлт | НОБГ-ын 2019 оны Сургуулийн жилийн зорилт, Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг зохион байгуулахад анхаарах асуудлууд | 2020.01.15 | 09:30-10:00 | | | | Захиргааны удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа Б.Баттулга |
| 2 | | Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг шинэлэг хэлбэрээр зохион байгуулах | | 10:00-10:30 | | | | Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, хурандаа Г.Нэргүй |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Мэдээллийн цаг | Цаг үетэй холбоотой үүрэг даалгавар | 2020.01.17 | 09:00-09:30 | | | | Нийслэлийн Онцгой байдлын газрын Тэргүүн дэд дарга, хурандаа Н.Нямхорлоо, Захиргааны удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа Б.Баттулга |
| 2 | Гамшгийн менежмент | Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр, Гамшгаас хамгаалах тухай хууль | | 09:30-10:30 | 1 | | | Захиргааны удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа Б.Баттулга |
| 1 | Мэдээллийн цаг | Цаг үетэй холбоотой үүрэг даалгавар | 2020.01.31 | 09:00-09:30 | | | | Нийслэлийн Онцгой байдлын газрын Тэргүүн дэд дарга, хурандаа Н.Нямхорлоо, Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, хурандаа Г.Нэргүй |
| 2 | Гамшгийн менежмент | Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам, Гамшгийн эрсдэлийн үнэлгээний нийтлэг заавар | | 09:30-10:30 | 1 | | | Дотоод хяналт шинжилгээ, үнэлгээ , эрсдэлийн удирдлагын тасгийн дарга, хошууч Ж.Төмөрмандах |
| 1 | Мэдээллийн цаг | Цаг үетэй холбоотой үүрэг даалгавар | 2020.02.14 | 09:00-09:30 | | | | Нийслэлийн Онцгой байдлын газрын Тэргүүн дэд дарга, хурандаа Н.Нямхорлоо, Гал түймэртэй тэмцэх хэлтсийн дарга, хурандаа Д.Мөнхсайхан |
| 2 | Гамшгийн менежмент | Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар /Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаал/ | | 09:30-10:30 | 1 | | | Газрын дэд дарга бөгөөд Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа Э.Эрдэнэбаатар |
| 1 | Мэдээллийн цаг | Цаг үетэй холбоотой үүрэг даалгавар | 2020.02.21 | 09:00-09:30 | | | | Нийслэлийн Онцгой байдлын газрын Тэргүүн дэд дарга, хурандаа Н.Нямхорлоо, |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Газрын дэд дарга бөгөөд Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа Э.Эрдэнэбаатар |
| 2 | Аюулгүй байдал, эрх зүйн үндэс | Команд штабын сургууль, дадлага зохион байгуулах заавар | | 09:30-10:30 | 1 | | | Газрын дэд дарга бөгөөд Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа Э.Эрдэнэбаатар |
| 1 | Мэдээллийн цаг | Цаг үетэй холбоотой үүрэг даалгавар | 2020.03.06 | 09:00-09:30 | | | | Нийслэлийн Онцгой байдлын газрын Тэргүүн дэд дарга, хурандаа Н.Нямхорлоо,<br>Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга, дэд хурандаа Д.Урантулга |
| 2 | Аюулгүй байдал, эрх зүйн үндэс | Шилэн данс, Санхүүгийн ил тод байдал | | 09:30-10:30 | 1 | | | Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга, дэд хурандаа Д.Урантулга |
| 1 | Мэдээллийн цаг | Цаг үетэй холбоотой үүрэг даалгавар | 2020.03.20 | 09:00-09:30 | | | | Нийслэлийн Онцгой байдлын газрын Тэргүүн дэд дарга, хурандаа Н.Нямхорлоо,<br>Захиргааны удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа Б.Баттулга |
| 2 | Аюулгүй байдал, эрх зүйн үндэс | Хууль эрх зүй, алба хаах журам | | 09:30-10:30 | 1 | | | Захиргаа удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа Б.Баттулга, |
| 1 | Мэдээллийн цаг | Цаг үетэй холбоотой үүрэг даалгавар | 2020.04.03 | 08:30-09:00 | | | | Нийслэлийн Онцгой байдлын газрын Тэргүүн дэд дарга, хурандаа Н.Нямхорлоо,<br>Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, хурандаа Г.Нэргүй |
| 2 | Аюулгүй байдал, эрх | Улсын хяналтын дүрэм, гал унтраах дүрэм, хөдөлмөр | | 09:00-10:00 | 1 | | | Гал түймэртэй тэмцэх хэлтсийн дарга, хурандаа Д.Мөнхсайхан |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зүйн үндэс | хамгаалал аюулгүй ажиллагаа | | | | | | |
| 1 | Мэдээллийн цаг | Цаг үетэй холбоотой үүрэг даалгавар | 2020.04.17 | 08:30-09:00 | | | | Нийслэлийн Онцгой байдлын газрын Тэргүүн дэд дарга, хурандаа Н.Нямхорлоо,<br>Гал түймэртэй тэмцэх хэлтсийн дарга, хурандаа Д.Мөнхсайхан |
| 2 | Аюулгүй байдал эрх зүйн үндэс | Гал унтраах анги, хэсэг, аврах нэгжид тавигдах шаардлага | | 09:00-10:00 | 1 | | | Гал түймэртэй тэмцэх хэлтсийн дарга, хурандаа Д.Мөнхсайхан |
| 1 | Мэдээллийн цаг | Цаг үетэй холбоотой үүрэг даалгавар | 2020.05.01 | 08:30-09:00 | | | | Нийслэлийн Онцгой байдлын газрын Тэргүүн дэд дарга, хурандаа Н.Нямхорлоо,<br>Газрын дэд дарга бөгөөд Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа Э.Эрдэнэбаатар |
| 2 | Аюулгүй байдал, эрх зүйн үндэс | Холбоо, зарлан мэдээллийг зохион байгуулах, Зарлан мэдээллийн дохиогоор ажиллах журам | | 09:00-10:00 | 1 | | | Газрын дэд дарга бөгөөд Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа Э.Эрдэнэбаатар |
| 1 | Мэдээллийн цаг | Цаг үетэй холбоотой үүрэг даалгавар | 2020.05.15 | 08:30-09:00 | | | | Нийслэлийн Онцгой байдлын газрын Тэргүүн дэд дарга, хурандаа Н.Нямхорлоо,<br>Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга, дэд хурандаа Д.Урантулга |
| 2 | Аюулгүй байдал, эрх зүйн үндэс | Авилгатай тэмцэх тухай хууль | | 09:00-10:00 | 1 | | | Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга, дэд хурандаа Д.Урантулга |
| 1 | Мэдээллийн цаг | Цаг үетэй холбоотой үүрэг даалгавар | 2020.05.29 | 08:30-09:00 | | | | Нийслэлийн Онцгой байдлын газрын Тэргүүн дэд дарга, хурандаа |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Н.Нямхорлоо,<br>Захиргааны удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа Б.Баттулга |
| 2 | Аюулгүй байдал, эрх зүйн үндэс | Хууль эрх зүй, Цэргийн албан хаагчийн сахилгын дүрэм, жагсаалын дүрэм | | 09:00-10:00 | 1 | | | Захиргааны удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа Б.Баттулга |
| 1 | Мэдээллийн цаг | Цаг үетэй холбоотой үүрэг даалгавар | 2020.06.12 | 08:30-09:00 | ' | | | Нийслэлийн Онцгой байдлын газрын Тэргүүн дэд дарга, хурандаа Н.Нямхорлоо,<br>Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, хурандаа Г.Нэргүй |
| 2 | Аюулгүй байдал, эрх зүйн үндэс | Хууль эрх зүй, Төрийн тусгай алба хаагчийн хувцас өмсөх, цол олгох журам | | 09:00-10:00 | 1 | | | Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, хурандаа Г.Нэргүй |
| 1 | Мэдээллийн цаг | Цаг үетэй холбоотой үүрэг даалгавар | 2020.06.26 | 08:30-09:00 | | | | Нийслэлийн Онцгой байдлын газрын Тэргүүн дэд дарга, хурандаа Н.Нямхорлоо,<br>Гал түймэртэй тэмцэх хэлтсийн дарга, хурандаа Д.Мөнхсайхан |
| 2 | Аюулгүй байдал, эрх зүйн үндэс | Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа | | 09:00-10:00 | 1 | | | Гал түймэртэй тэмцэх хэлтсийн дарга, хурандаа Д.Мөнхсайхан |
| 1 | Мэдээллийн цаг | Цаг үетэй холбоотой үүрэг даалгавар | 2020.08.14 | 08:30-09:00 | | | | Нийслэлийн Онцгой байдлын газрын Тэргүүн дэд дарга, хурандаа Н.Нямхорлоо,<br>Газрын дэд дарга бөгөөд Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа Э.Эрдэнэбаатар |
| 2 | Аюулгүй | Батлан хамгаалах бодлогын | | 09:00-10:00 | 1 | | | Газрын дэд дарга бөгөөд Гамшгийн |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байдал эрх зүйн үндэс | үндэс, Монгол Улсын Цэргийн номлол | | | | | | шуурхай удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа Э.Эрдэнэбаатар |
| X | Мэдээллийн цаг | Цаг үетэй холбоотой үүрэг даалгавар | 2020.08.28 | 08:30-09:00 | | | | Нийслэлийн Онцгой байдлын газрын Тэргүүн дэд дарга, дэд хурандаа Н.Нямхорлоо, Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга, дэд хурандаа Д.Урантулга |
| 2 | Аюулгүй байдал, эрх зүйн үндэс | Төсвийн тухай хууль | | 09:00-10:00 | 1 | | | Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга, дэд хурандаа Д.Урантулга |
| 1 | Мэдээллийн цаг | Цаг үетэй холбоотой үүрэг даалгавар | 2020.09.11 | 09:00-09:30 | | | | Нийслэлийн Онцгой байдлын газрын Тэргүүн дэд дарга, дэд хурандаа Н.Нямхорлоо, Захиргааны удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа Б.Баттулга |
| 2 | Аюулгүй байдал, эрх зүйн үндэс | Сахилга ёс зүйн хяналтын хуудас хэрэглэх журам, алба хаагчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам | | 09:30-10:30 | 1 | | | Захиргааны удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа Б.Баттулга |
| 1 | Мэдээллийн цаг | Цаг үетэй холбоотой үүрэг даалгавар | 2020.09.25 | 09:00-09:30 | | | | Нийслэлийн Онцгой байдлын газрын Тэргүүн дэд дарга, хурандаа Н.Нямхорлоо, Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, хурандаа Г.Нэргүй |
| 2 | Аюулгүй байдал, эрх зүйн үндэс | Хууль эрх зүй, Төрийн тусгай алба хаагчийн ёс зүйн дүрэм, оны тэргүүний хамт олон, оны шилдэг албан хаагчдыг | | 09:30-10:30 | 1 | | | Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, хурандаа Г.Нэргүй |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | шалгаруулах журам | | | | | | |
| 1 | Мэдээллийн цаг | Цаг үетэй холбоотой үүрэг даалгавар | 2020.10.09 | 09:00-09:30 | | | | Нийслэлийн Онцгой байдлын газрын Тэргүүн дэд дарга, хурандаа Н.Нямхорлоо,<br>Гал түймэртэй тэмцэх хэлтсийн дарга, хурандаа Д.Мөнхсайхан |
| 2 | Аюулгүй байдал, эрх зүйн үндэс | Хорт хий утаанаас хамгаалах дүрэм, байршил тогтоогч GPS-ийн ажиллах дүрэм | | 09:30-10:30 | 1 | | | Гал түймэртэй тэмцэх хэлтсийн дарга, хурандаа Д.Мөнхсайхан |
| 1 | Мэдээллийн цаг | Цаг үетэй холбоотой үүрэг даалгавар | 2020.10.23 | 09:00-09:30 | | | | Нийслэлийн Онцгой байдлын газрын Тэргүүн дэд дарга, хурандаа Н.Нямхорлоо,<br>Газрын дэд дарга бөгөөд Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа Э.Эрдэнэбаатар |
| 2 | Аюулгүй байдал, эрх зүйн үндэс | Гамшгийн нөхцөл байдлын талаар мэдээлэл цуглуулах, боловсруулалт, үнэлгээ хийх, дүгнэлт гаргах | | 09:30-10:30 | 1 | | | Газрын дэд дарга бөгөөд Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа Э.Эрдэнэбаатар |
| 1 | Мэдээллийн цаг | Цаг үетэй холбоотой үүрэг даалгавар | 2020.11.06 | 09:00-09:30 | | | | Нийслэлийн Онцгой байдлын газрын Тэргүүн дэд дарга, хурандаа Н.Нямхорлоо,<br>Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга, дэд хурандаа Д.Урантулга |
| 2 | Аюулгүй байдал, эрх зүйн үндэс | Алдар цолтон ахмад настанд тэтгэвэр нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хууль | | 09:30-10:30 | 1 | | | Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга, дэд хурандаа Д.Урантулга |
| 1 | Мэдээллийн цаг | Цаг үетэй холбоотой үүрэг даалгавар | 2020.11.20 | 09:00-09:30 | | | | Нийслэлийн Онцгой байдлын газрын Тэргүүн дэд дарга, хурандаа |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Н.Нямхорлоо, Газрын дэд дарга бөгөөд Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа Э.Эрдэнэбаатар |
| 2 | Аюулгүй байдал, эрх зүйн үндэс | Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дайчлах аж ахуй нэгж байгууллага, иргэдийн оролцоо | | 09:30-10:30 | 1 | | | Газрын дэд дарга бөгөөд Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа Э.Эрдэнэбаатар |
| 1 | Мэдээллийн цаг | Цаг үетэй холбоотой үүрэг даалгавар | 2020.12.04 | 09:00-09:30 | | | | Нийслэлийн Онцгой байдлын газрын Тэргүүн дэд дарга, хурандаа Н.Нямхорлоо, Захиргааны удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа Б.Баттулга |
| 2 | Аюулгүй байдал, эрх зүйн үндэс | Хууль эрх зүй, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль | | 09:30-10:30 | 1 | | | Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, хурандаа Г.Нэргүй |
| Төв байрны алба хаагчдын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх, англи орос хэлний анхан шатны сургалт | | | Жилд 16 цагийн хичээл, 5 цагийн дадлага, 8 цагийн семинар, нийт 29 цаг | | | | | |
| | Нийт | | 22 удаа | 32 цаг | | | | |
| ОФИЦЕР БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГАЛТ | | | | | | | | |
| 1 | | Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлтгэл, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн болон Гал түймрийн улсын хяналтын байцаагч, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн | 2020 оны 1 дүгээр улиралд | 09:00-18:00 2 өдөр | | 11 | 5 | Захиргааны удирдлагын хэлтэс, Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтэс, Гамшгийн шуурхай удирдлагын хэлтэс, Гал түймэртэй тэмцэх хэлтэс, Санхүү, эдийн засгийн хэлтэс |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Бие бүрэлдэхүүн | Гал түймэр унтраах, аврах ангийн салааны захирагч, НАА-105-ын бүлгийн дарга | 2020 оны 1 дүгээр улиралд | 09:00-18:00<br>2 өдөр | | 11 | 5 | Захиргааны удирдлагын хэлтэс,<br>Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтэс,<br>Гал түймэртэй тэмцэх хэлтэс,<br>Санхүү, эдийн засгийн хэлтэс |
| 3 | | Гал түймэр унтраах, аврах ангийн захирагч | 2020 оны 2 дугаар улиралд | 09:00-18:00<br>2 өдөр | | 11 | 5 | Захиргааны удирдлагын хэлтэс,<br>Гал түймэртэй тэмцэх хэлтэс,<br>Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтэс |
| Заагдсан сэдвүүдээр шүүлэг авах | | | | | | 33 | 15 | Хариуцсан хэлтэс |
| АХЛАГЧ БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГАЛТ | | | | | | | | |
| 1 | Бие бүрэлдэхүүн | Нийслэлийн Аврах анги 105, Гал түймэр унтраах аврах ангиудын шуурхай албаны автомашины жолооч | 2020 оны 3 дугаар улиралд | 09:00-18:00<br>2 өдөр | | 11 | 5 | Захиргааны удирдлагын хэлтэс,<br>Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтэс,<br>Гал түймэртэй тэмцэх хэлтэс,<br>Санхүү, эдийн засгийн хэлтэс |
| 2 | | Гал түймэр унтраах аврах ангийн нярав, багны засварчин | 2020 оны 2 дугаар улиралд | 09:00-18:00<br>2 өдөр | | 11 | 5 | Захиргааны удирдлагын хэлтэс,<br>Гал түймэртэй тэмцэх хэлтэс,<br>Санхүү, эдийн засгийн хэлтэс |
| 3 | | Гал түймэр унтраах, Аврах ангийн холбоочин, шуурхай удирдлагын оператор | 2020 оны 3 дугаар улиралд | 09:00-18:00<br>2 өдөр | | 11 | 5 | Гамшгийн шуурхай удирдлагын хэлтэс,<br>Гал түймэртэй тэмцэх хэлтэс,<br>Санхүү, эдийн засгийн хэлтэс |
| Заагдсан сэдвүүдээр шүүлэг авах | | | | | | 33 | 15 | Хариуцсан хэлтэс |

—oOo—